

## **Сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хооронд харилцан ойлголцох боломж судалгаа**

*Д.Чимгээ, МУИС-ийн ЭЗС-ийн багши, доктор, дэд профессор  
Л.Батцэцэг, ADRA төслийн ажилтан, магистр*

Сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хооронд харилцан ойлголцох боломжс, сонсголын бэрхшээлтэй иргэдэд халамжс, үйлчилгээ үзүүлжс буй сургууль, байгууллагуудын мэргэжилтийн дохионы хэлний мэдлэг, тэдний хандлага, дадал ямар байгааг тодорхойлох, түүнчлэн дохионы хэлний анхан шатны сургалтын үр дүн, өгөөжийг тодорхойлоход зорилгоор энэхүү судалгааг хийсэн.

Дохионы хэлний анхан шатны сургалтанд сонсголын бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэд, тэдний гэр бүлийн гишүүд, үе тэнгийн нийт 369 хүн хамрагдсанас мэдлэг хандлага, дадлыг тодорхойлох уг судалгаанд 95 хүн буюу нийт сургалтанд оролцогчдын 25.7 хувь нь хамрагдсан.

Дохионы хэлний анхан шатны сургалтаар сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн дохионы хэлний мэдлэг, чадвар дээшилсэн хувь өндөр байгаа нь сургалт чухал ач холбогдолтой, үр дүнтэй болсныг илтгэж байна. Сонсголтой иргэд сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харьцах, мөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн нилээд хэсэг нь жирийн иргэдтэй огт харьцааж чаддаггүй байна. Үүний гол шалтгаан нь сонсголтой иргэдийн хувьд дохио мэддэггүй, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгмийн талаас нэгдсэн дохионы хэл байхгүй явдал байв. Харин хувь хүний талаас харшицаанд орж чадахгүй байх гэж эмээдэг, бусдаас хол байх эрмэлзэлтэй байдаг гэжээ. Сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь төр засгаас сонсголын бэрхшээлтэй иргэдэд тусалж чадна хэмээн илтгэж явдаг ажээ. Сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн үзэжс буйгаар тэдэнд нэн тэргүүнд сурч хөгжих боломж нөхцөл, тайван түгшиүүргүй амьдрал, хөдөлмөр эрхлэлт хамгийн хэрэгтэй байна.

Судалгааны үр дүнгээс дохионы хэлний анхан шатны сургалтыг насын онцлог, байришил, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтмол явуулжс байх, сургалтаар олж авсан мэдлэгээ амьдралд хэрэглэх боломжс, нөхцөл буй эсэхэд анхаарч давтан сургалтанд хамруулах, телевиз болон олон нийтийн мэдээлэх хэрэгслээр мэдээллийг дохионы хэлээр явуулах, олон нийтэд ойлголт, мэдлэг олгох сургалтуудыг явуулах хэрэгтэй гэсэн санлыг тавьжс байна. Түүнчлэн, сонсголын бэрхшээлтэй иргэдэд сурч хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэх, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, сонсголын бэрхшээлтэй иргэдийн оршин суугаа дүүрэг, ажил амьдралын орчинг тайван, алуулгүй байлагах нөхцөл боломжсоор хангах, сонсголын бэрхшээлтэй иргэдэд хандсан нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дээшилүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд энэ чиглэлээр хийгдэжс байгаа санаачлагуудыг дэмжих, хамтран ажиллахыг төр, олон нийт болон боловсролын байгууллагуудыг уриалах ажлыг зохион байгуулах хэрэгтэй юм.

### **Үндэслэл**

АДРА Монгол байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлж буй боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн боловсрол төслийг Словак улсын Засгийн газрын санхүүжилтээр 2005 оноос нэг жилийн хугацаатай хэрэгжүүлсэн юм. Энэ төслийн хүрээнд хийгдсэн зарим нэг ажлаас цухасхан дурьдвал харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан монгол хэл дээрх текстийг яриа болгон унших компьютерийн программ, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан Монголын дохионы хэлний анхны толь бичгийг БСШУЯ, НҮБХС, Азиател ХХК зэрэг байгууллагуудтай хамтран боловсруулан гаргасан. Түүнчлэн сонсголын бэрхшээлтэй иргэдийг нийгмийн идэвхтэй харилцаанд татаан оролцуулах, жирийн иргэдтэй хамт сурч, боловсрох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх төрийн халамж, үйлчилгээний салбарын мэргэжилтнүүд, сонсголын бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэд, тэдний гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхний дунд дохионы хэлний мэдлэг олгох 5 өдрийн сургалтыг 2005 оны 10 сараас 2006 оны 3 сарын хооронд 32 удаа зохион байгуулж нийт 656 хүнийг хамрууллаа.

Эдгээр сургалтуудын үр өгөөж, сонсголын бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, тэдэнд халамж, үйлчилгээ үзүүлэгч багш, мэрэгжилтэнүүдийн эзэмшсэн дохионы хэлний мэдлэг, харилцан ойлголцох ур чадварыг тодорхойлох зорилгоор сургалтанд явагдснаас хойш 2-5 сарын дараа мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааг хийсэн болно.

### *Судалгааны зорилго, зорилт*

Судалгааны зорилго нь сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хооронд харилцан ойлголцох боломж, сонсголын бэрхшээлтэй иргэдэд халамж, үйлчилгээ үзүүлж буй сургууль, байгууллагуудын мэргэжилтнүүдийн дохионы хэлний мэдлэг, тэдний хандлага, дадал ямар байгааг тодорхойлох, түүнчлэн дохионы хэлний анхан шатны сургалтын үр дүн, өгөөжийг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилгыг биелүүлэхийн тулд дараах үндсэн зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн явуулсан сургалтын үр өгөөж, тэдний дохионы хэлний мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох, дохионы хэлний хэрэгцээг тогтоох;
- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй сургууль, байгууллагуудын мэргэжилтнүүдэд явуулсан сургалтын үр өгөөж, тэдний дохионы хэлний мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох;

### *Судалгааны шинэлэг тал ба ач холбогдол*

Манай орны хувьд урьд өмнө нь энэ чиглэлээр судалгаа хийгдэж байгаагүй. Судалгаа нь зөвхөн тухайн төслийн үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөхөд шаардлагатай төдийгүй сонсголын бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд болон тэдэнд үйлчилгээ үзүүлж буй сургууль, байгууллагуудын мэргэжилтнүүдэд дохионы хэлний сургалт ач холбогдолтой эсэх, сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах боломжийн талаарх тэдний ойлголт, хэрэгцээг судлан тогтоосонд уг ажлын шинэлэг тал оршино.

Судалгааны ажлын ач холбогдол нь судалгааны үр дүнд тулгуурлан гаргасан зөвлөмж бөгөөд энэ нь цаашид сонсголын бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн

гишүүд болон тэдэнд үйлчилж буй сургууль, байгууллагын мэргэжилтнүүдийн хандлагыг эерэгээр төлөвшүүлэх, дохионы хэлний хэрэглээг нэмэгдүүлэх, тэдэнд явуулах дохионы хэлний сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах үйл ажиллагааны чиглэл, түүний үндэслэлийг гаргаж тавьсан явдал юм.

### ***Судалгааны хүрээ***

Судалгааны хүрээнд дохионы хэлний анхан шатны сургалтанд оролцсон хүмүүсийг хамруулан авч үзсэн. Судалгааны хүрээ нь:

- Сонсголтой ба сонсголгүй хүүхэд, насанд хүрэгсэд
- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд халамж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын багш, мэргэжилтнүүд гэсэн 2 дэд хүрээг хамарсан болно.

Судалгаанд нийтдээ 185 хүн, үүнээс 36 сонсголтой ба 59 сонсголгүй иргэд, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн 33 багш, төрийн халамж, үйлчилгээний байгууллагуудын 57 мэргэжилтнүүдийг хамруулсан нь дохионы хэлний анхан шатны сургалтанд оролцогчдын 28.2 хувь нь болно. Мэдээллийг 2006 оны 2 дугаар сараас 3 дугаар сарын хооронд цуглуулав.

Судалгааны удирдамжийн дагуу урьдчилан бэлтгэсэн асуумжаар төслийн дохионы хэлний сургагч багш Ё. Чимгээ, Б. Чинбаатар, Я. Оюунзул нар мэдээллийг цуглуулсан.

### ***Судалгааны асуумжийн бүтэц***

**Асуумж 1.** Сонсголын бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэнд зориулсан асуулга, түүний үр дүн

*Нийгэм, эдийн засгийн байдал*

- Нас, боловсрол, ажил эрхлэлт

*Сургалтын үр, өгөөж, түүний хэрэгцээ*

- Сургалтын талаарх үнэлгээ
- Харилцааны үр чадвар ба түүнд тохиолдож буй бэрхшээл

*Дохионы хэлний мэдлэг*

- Хурууны үсэг
- Дохионы хэл
- Хурууны үсэг, дохионы хэлний хэрэглээ

**Асуумж 2.** Мэргэжилтнүүд

*Нийгэм, эдийн засгийн байдал*

- Нас, боловсрол, ажил эрхлэлт

*Сургалтын үр, өгөөжс, түүний хэрэгцээ*

- Дохионы хэлний сургалтын үр дүнгийн талаарх үнэлгээ
- Сонсголын бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага

*Дохионы хэлний мэдлэг, түүний хэрэгцээ*

- Хурууны үсэг
- Дохионы хэл
- Хурууны үсэг, дохионы хэлний хэрэглээ

**Судалгааны мэдээлэл боловсруулалт, үр дүнгийн тайлан гаргалт**

Судалгааны мэдээллийг урьдчилан бэлтгэсэн дээрх 2 асуумжийн маягтыг (Хавсралт) ашиглан цуглуулав. Тодорхой шалтгаангүйгээр орхигдсон болон алдаатай бөглөгдсөн мэдээллийг дахин бөглүүлэхийг мэдээлэл цуглуулагч нар хариуцаж ажилласан ба цуглуулсан мэдээллийн бүрэн байдлын хяналтыг төслийн менежер хийж, энэ нь боломжгүй үед логик шинжилгээгээр тодорхойлж, цуглуулсан мэдээллийн бүрэн байдлыг хангав.

Судалгааны мэдээллийг компьютерт оруулахын тулд түүнд ангилал, кодчлол хийллээ. Мэдээлэл боловсруулалт болон шинжилгээ, тайланг дараах байдлаар бүлэглэн хийсэн.

- Сонсголтой буюу сонсголын бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэд
- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд халамж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын багш, мэргэжилтнүүд

Мэдээлэл боловсруулалт болон шинжилгээг нийгмийн судалгаанд зориулсан SPSS 11.5 программыг ашиглан гүйцэтгэсэн.

**1. Сонсголтой болон сонсголгүй иргэдээс авсан судалгааны үр дүн**

**1.1 Нийгэм, эдийн засгийн байдал**

Дохионы хэлний анхан шатны сургалтанд сонсголын бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэд, тэдний гэр бүлийн гишүүд, үе тэнгийн нийт 369 хүн хамрагдсанаас мэдлэг хандлага, дадлыг тодорхойлох судалгаанд 95 хүн буюу нийт сургалтанд оролцогчдын 25.7 хувь нь хамрагдсан байна. Судалгаанд хамрагдагсдыг хүйс болон сонсголын байдлаар нь харуулав (Хүснэгт 1).

**Xүснэгт 1. Судалгаанд оролцогчдын сонголын байдал, хүйсээр, тоо ба сонголын байдалд эзлэх хувиар**

| Үзүүлэлт        | Хүйс      |          | Нийт дүн<br>Too/ хувь |
|-----------------|-----------|----------|-----------------------|
|                 | Эрэгтэй   | Эмэгтэй  |                       |
| Сонголын байдал | Сонголтой | 25.0(9)  | 75.0(27)              |
|                 | Сонголгүй | 40.7(24) | 59.3(35)              |
| Дүн             |           | 34.7(33) | 65.3(62)              |
|                 |           |          | 100.0(95)             |

Судалгаанд хамрагдагсдын 62.1 хувь буюу 59 хүн сонголын бэрхшээлтэй байсан бол дохионы хэлний сургалтанд хамрагдсан нийт оролцогчдын 56.4 хувь буюу 208 хүн нь сонголын бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэд байв.

Судалгаанд хамрагдагсдын нас болон боловсролын байдлын үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

**Xүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын нийгэм, эдийн засгийн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр**

| Үзүүлэлт               | Хүйс      |          | Нийт дүн  |
|------------------------|-----------|----------|-----------|
|                        | Эрэгтэй   | Эмэгтэй  |           |
| 1. Насны бүлгээр       |           |          |           |
| 18 нас хүртэл          | 32.7 (17) | 67.3(35) | 100.0(52) |
| 19-25 нас              | 66.7(10)  | 33.3(5)  | 100.0(15) |
| 26-45 нас              | 11.1(2)   | 88.9(16) | 100.0(18) |
| 46 наснаас дээш        | 40.0(4)   | 60.0(6)  | 100.0(10) |
| 2. Боловсролын байдал  |           |          |           |
| Бага буюу түүнээс доош | 38.9(7)   | 61.1(11) | 100.0(18) |
| Бүрэн бус дунд         | 46.3(19)  | 53.7(22) | 100.0(41) |
| Бүрэн дунд             | 17.6(3)   | 82.4(14) | 100.0(17) |
| Тусгай дунд            | 12.5(1)   | 87.5(7)  | 100.0(8)  |
| Дээд                   | 27.3(3)   | 72.7(8)  | 100.0(11) |

Сургалтанд оролцогчдын 57.2 хувь буюу 211 нь эмэгтэйчүүд байсан бол судалгаанд хамрагсдын 65.3 хувь буюу 59 хүн нь эмэгтэйчүүд байна. 18 хүртэлх насныхан 67.3 хувь, 26-45 насныхан 88.9 хувь, 46-аас дээш насныхан 60 хувийг эмэгтэйчүүд эзэлж байв. Харин 19-25 насны бүлэгт эрэгтэйчүүд (66.7) илүү хамрагдсан байна. Тэдгээрийн боловсролын байдлыг авч үзэхэд 41 хүн бүрэн бус дунд боловсролтой ба үүний 53.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанд хамрагдсан сонголын бэрхшээлтэй иргэдийн мэргэжил ба эрхэлж буй албан тушаалыг авч үзэхэд ажиллаж буй хүмүүсийн мэргэжил нь нарийн боовчин, мужаан зэрэг байгаа бол сургалтын төвд сурч буй суралцагчдын эзэмшиж байгаа мэргэжил нь ихэвчлэн гоо сайханч, тогооч, оёдолчин, ногоочин байна. Эндээс сонголын бэрхшээлтэй иргэд сургуульд хангалттай хамрагддаг мэт харагдаж болох боловч дохионы хэлний сургалтанд хамрагдагсаас тодорхой харьяалалтай, холбоо тогтоох боломжтой хүмүүсээс уг судалгаанд хамруулсан гэдгийг дурьдах нь зүйтэй.

Сонсголтой иргэдээс авах судалгааг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль болох 29 дүгээр сургуулийн сурагчдаар дамжуулан тэдний гэр бүлийн гишүүдээс авсан ба тэдний дунд тодорхой ажил эрхэлдэггүй хүмүүсийн хувь нилээд өндөр, сурч боловсрол эзэмшиж буй иргэдийн хувь ч харьцангуй бага байлаа. Энэ нь төслөөс зохион байгуулсан дохионы хэлний сургалтын хугацаа 5 өдөр байснаас тухайн гэр бүлийн тодорхой эрхэлсэн ажил албагүй гишүүд дохионы хэлний сургалтанд түлхүү оролцоход хүргэсэн болно.

## *1.2 Сургалтын үр өгөөж*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол төслөөс зохион байгуулсан дохионы хэлний анхан шатны сургалтын ач холбогдлыг сургалтанд хамрагдагч сонсголтой иргэдийн 84.2 хувь, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 72.9 хувь нь (Хүснэгт 3) сургалтыг маш чухал ач холбогдолтой болсон гэж дүгнэжээ.

*Хүснэгт 3. Дохионы хэлний анхан шатны сургалтын ач холбогдолтой болсон гэж дүгнэжээ*

|   |                             | Дохионы хэлний анхан шатны сургалтын ач холбогдлыг хэрхэн үнэлж байна вэ | Хүйс    |         | Дүн   |
|---|-----------------------------|--|---------|---------|-------|
|   |                             |  | Эрэгтэй | Эмэгтэй |       |
| А | Сонсголтой иргэд            | Чухал бус  | 2.11    | 0.0     | 2.11  |
|   |                             | Чухал  | 0.0     | 13.65   | 13.65 |
|   |                             | Маш чухал  | 22.29   | 61.95   | 84.2  |
|   | Дүн                         |  | 24.4    | 75.6    | 100.0 |
|   |                             | Дунд зэрэг   | 0.0     | 2.11    | 2.11  |
|   |                             | Чухал  | 13.6    | 10.2    | 23.8  |
| Б | Сонсголын бэрхшээлтэй иргэн | Маш чухал  | 27.1    | 45.8    | 72.9  |
|   |                             | Дун  | 40.7    | 59.3    | 100.0 |

Тиймээс дохионы хэлний анхан шатны сургалт нь сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд чухал ач холбогдолтой болсон төдийгүй тэд хэл дохионы мэдлэг чадвар олгох үндсэн зорилгодоо хүрчээ гэж үзэж болохоор байна.

## *1.3 Сургалтаар олж авсан мэдлэг, чадварын үнэлгээ*

Сургалтын үр дүн, түүний ач холбогдлыг судалгаанд хамрагдагч сонсголтой иргэдийн өөртөө өгсөн үнэлгээ, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд асуулгад хариулж буй байдлыг судалгаа авагчийн зүгээс үнэлсэн байдалд үндэслэн хийсэн.

Судалгаанд хамрагдагсдын 66.3 хувь нь хурууны үсгийн мэдлэгээ онц гэж дүгнэсэн бол 56.8 хувь нь дохионы мэдлэгийнхээ түвшинг онц гэж дүгнэжээ. Энэ нь сургалтын хөтөлбөрөөр заасан хурууны үсэг болон дохионы хичээлийн үр өгөөж өндөр байсныг нотолж байна (Хүснэгт 4).

**Хүснэгт 4. Сургалтын дараах дохионы хэлний мэдлэгийн түвшин**

| Үнэлгээ    | Бичиг<br>үсгийн<br>чадвар | Хурууны<br>үсэг | Дохио | Хурууны<br>үсэг,<br>дохионы<br>хэрэглээ | Сонсголтой буюу<br>сонсголгүй хүнтэй<br>харьцах чадвар |
|------------|---------------------------|-----------------|-------|---|--|
| Муу        | 1.1                       | 0.0             | 0.0   | 3.2                                     | 10.5   |
| Дунд зэрэг | 14.7                      | 10.5            | 21.1  | 41.1                                    | 23.2   |
| Сайн       | 25.3                      | 23.2            | 22.1  | 31.6                                    | 43.2   |
| Онц        | 58.9                      | 66.3            | 56.8  | 24.2                                    | 23.2   |
| Бүгд       | 100.0                     | 100.0           | 100.0 | 100.0                                   | 100.0  |

Мөн дээрх хүснэгтээс харахад судалгаанд хамрагдагсдын 89.6 хувь нь сонсголтой буюу сонсголгүй хүнтэй харьцах чадвараа дундаас дээш гэсэн бол хурууны үсэг ба дохионы хэрэглээгээ дийлэнх хувь буюу 96,8 хувь нь дунд зэрэг ба түүнээс дээш гэж дүгнэжээ. Эндээс үзэхэд хурууны үсэг болон дохионы хамтад нь ашиглах болон сонсголтой ба сонсголгүй хүнтэй харьцах мэдлэг чадварыг сургалтанд хамрагдагсад хангалттай түвшинд эзэмшсэнийг харуулж байна.

Сургалтын дараах мэдлэгийн түвшинг одоогийн мэдлэгийн түвшинтэй харьцуулан дүгнэхэд үзэхэд бичиг үсгийн чадвараа онц хэмээн тодорхойлсон хүмүүсийн хувь 58.9 байсан бол энэхүү үзүүлэлт буурч 46.3 болсон, мөн хурууны үсгийн мэдлэгийн түвшингээ онц гэж дүгнэсэн хүмүүсийн хувь 66.3 байснаа 45.3 болж нийт дүнгээрээ доошилсон байна. Дохионы мэдлэг нь онц байсан хүмүүсийн эзлэх хувь 56.8 байсан бол 34.7 болтлоо доошилжээ. Энэ нь сургалтанд хамрагдсан хүмүүсийн сургалтаар эзэмшсэн бичиг үсэг, хурууны үсэг болон дохионы мэдлэг чадвар нь буурч байна гэж судалгаанд хамрагдагсад өөрсдийгөө үнэлжээ (Хүснэгт 5).

**Хүснэгт 5. Дохионы хэлний мэдлэгийн түвшин одоогийн байдлаар**

| Үнэлгээ    | Бичиг<br>үсгийн<br>чадвар | Хурууны<br>үсэг | Дохио | Хурууны<br>үсэг,<br>дохионы<br>хэрэглээ | Сонсголтой буюу<br>сонсголгүй хүнтэй<br>харьцах чадвар |
|------------|---------------------------|-----------------|-------|---|--|
| Муу        | 5.3                       | 6.3             | 4.2   | 8.4                                     | 7.4  |
| Дунд зэрэг | 7.4                       | 11.6            | 16.8  | 20.0                                    | 23.2   |
| Сайн       | 41.1                      | 36.8            | 44.2  | 35.8                                    | 40.0   |
| Онц        | 46.3                      | 45.3            | 34.7  | 35.8                                    | 29.5   |
| Нийт дун   | 100.0                     | 100.0           | 100.0 | 100.0                                   | 100.0  |

Харин хурууны үсэг ба дохионы хэрэглээг хамт ашигладаг мэдлэгээ дунд зэрэг гэж дүгнэсэн хүмүүсийн эзлэх хувь одоогийн байдлаар буурсан бөгөөд сайн буюу онц гэж дүгнэсэн хүмүүсийн хувь өсчээ. Сонсголтой ба сонсголгүй иргэдтэй харьцах чадвараа онц гэж үнэлсэн хүмүүсийн эзлэх хувь нэмэгдсэн байна. Энэ нь хурууны үсэг болон дохиог ашиглах, мөн сонсголтой ба сонсголгүй иргэдтэй харьцах мэдлэг чадвар нь одоогийн байдлаар сургалтын дараах түвшингээс дээшилсэн гэж судалгаанд хамрагдагсад үзэж байгааг харуулж байна.

#### 1.4 Оролцогчийн дохионы хэлний мэдлэг

Судалгаанд хамрагдагсдын дохионы хэлний мэдлэгийг судалгааны явцад дохионы хэлний сургагч багш нарын авсан шалгалтын үнэлгээнд үндэслэв. Шалгалтын үр

дүнг нийт хүмүүс, үүнээс сонсголтой ба сонсголгүй иргэдийн бүлгээр тооцож (Хүснэгт 6) харуулав. Хүснэгтээс харахад нийт хамрагдагсдын 88.4, сонсголтой иргэдийн 94.5, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 82.8 хувь нь дүрмийн дагуу уншигдахаар дохиж байгаа эсэх үзүүлэлтээр сайн ба түүнээс дээш үнэлгээ авчээ. Ялангуяа, сонсголтой иргэдийн сургалтын амжилт энэ үзүүлэлтээр өндөр байна.

Сургалтын амжилтын дундаж дунг нийт хамрагдагсдаар авч үзэхэд аль ч үзүүлэлтээр ерөнхийдөө дундаж дүнгүүд ойролцоо буюу 4.02-4.41 хооронд байгаа бөгөөд ерөнхий дундаж нь 4.18 буюу сайнаас дээш гэсэн үнэлгээтэй байна. Энэ нь судалгаанд хамрагдагсдын дохионы хэлний мэдлэгийн ерөнхий түвшин сайн байгааг харуулж байна. Харин сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн бүлгээр тус тус тооцоход ерөнхий дундаж нь адилхан 4.18 байгаа ч сонсголтой иргэдийн хувьд үнэлгээний эхний 5 үзүүлэлтээр өндөр, сүүлийн 3 үзүүлэлтээр доогуур байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дохионы хэлний үнэлгээнд хийсэн шинжилгээний дээрх үр дүнгээс харахад сургалтанд оролцогчид дохионы хэлний зохих мэдлэгийг эзэмшсэн ба энэ нь сургалтаар олж авсан мэдлэг нь сонсголтой эсвэл сонсголын бэрхшээлтэй эсэхээс үл хамааран харьцангуй жигд түвшинд байна гэж үзлээ. Энэ байдал нь сургалтын үр өгөөж өндөр, ямар нэгэн ялгаварлалгүйгээр дохионы мэдлэгийг бүх оролцогчдод олгосон нь харагдаж байна.

Үүнээс сонсголтой иргэд сургалтанд хамрагдснаар дохионы хэлний мэдлэгтэй болсон хэдий ч харилцаанд ашиглах буюу хэрэглээний дадал нь сонсголын бэрхшээлтэй хүнтэй харьцуулахад дутмаг болохыг харуулж байна.

#### Xүснэгт 6. Дохионы хэлний үнэлгээ (Хувиар)

|                               | Дүрмийн<br>дагуу<br>уншигдахаар<br>дохиж байгаа<br>эсэх | Ижил<br>төстэй<br>Үсгүүдийн<br>ялгааг<br>гаргаж<br>чадаж<br>байгаа эсэх | Дактель<br>үсэг<br>марсан<br>эсэх | Дохих ур<br>чадвар | Дохиог<br>зургаас<br>харж ойлгох<br>чадвар | Дохиог<br>марсан<br>эсэх | Асуух<br>дохиог<br>ойлгох,<br>хариултыг<br>зөв дохиж<br>хариулах<br>чадвар | Үгийн утвыг<br>оилгох,<br>өгүүлбэрт<br>ашиглах<br>чадвар |
|-------------------------------|---|---|-----------------------------------|--------------------|--|--------------------------|--|--|
| Тоо                           | 95  | 95  | 95                                | 95                 | 95   | 95                       | 95   | 95   |
| < 60                          | 2.1   | 2.1   | 2.1                               | 4.2                | 5.3  | 5.3                      | 4.2  | 4.2  |
| 61-73                         | 9.5   | 16.8  | 20.0                              | 16.8               | 15.8                                       | 24.2                     | 17.9   | 18.9   |
| 74-89                         | 33.7  | 29.5  | 28.4                              | 36.8               | 37.9                                       | 33.7                     | 45.3   | 41.1   |
| 90-100                        | 54.7  | 51.6  | 49.5                              | 42.1               | 41.1                                       | 36.8                     | 32.6   | 35.8   |
| Бүгд                          | 100.0   | 100.0   | 100.0                             | 100.0              | 100.0                                      | 100.0                    | 100.0  | 100.0  |
| Үүнээс:                       |   |   |                                   |                    |  |                          |  |  |
| Сонсголтой (too)              | 36  | 36  | 36                                | 36                 | 36   | 36                       | 36   | 36   |
| < 60                          | 0.0   | 0.0   | 0.0                               | 2.8                | 5.6  | 2.8                      | 2.8  | 2.8  |
| 61-73                         | 5.6   | 5.6   | 16.7                              | 22.2               | 16.7                                       | 30.6                     | 22.2   | 27.8   |
| 74-89                         | 30.6  | 38.9  | 30.6                              | 38.9               | 41.7                                       | 38.9                     | 50.0   | 41.7   |
| 90-100                        | 63.9  | 55.6  | 52.8                              | 36.1               | 36.1                                       | 27.8                     | 25.0   | 27.8   |
| Бүгд                          | 100.0   | 100.0   | 100.0                             | 100.0              | 100.0                                      | 100.0                    | 100.0  | 100.0  |
| Сонсголгүй (too)              | 59  | 59  | 59                                | 59                 | 59   | 59                       | 59   | 59   |
| < 60                          | 3.4   | 3.4   | 3.4                               | 5.1                | 5.1  | 6.8                      | 5.1  | 5.1  |
| 61-73                         | 11.9  | 23.7  | 22.0                              | 13.6               | 15.3                                       | 20.3                     | 15.3   | 13.6   |
| 74-89                         | 35.6  | 23.7  | 27.1                              | 35.6               | 35.6                                       | 30.5                     | 42.4   | 40.7   |
| 90-100                        | 49.2  | 49.2  | 47.5                              | 45.8               | 44.1                                       | 42.4                     | 37.3   | 40.7   |
| Бүгд                          | 100.0   | 100.0   | 100.0                             | 100.0              | 100.0                                      | 100.0                    | 100.0  | 100.0  |
| Сонсголтой<br>иргэдийн дундаж | 4.58  | 4.50  | 4.36                              | 4.08               | 4.08                                       | 3.92                     | 3.97   | 3.94   |
| Сонсголгүй<br>иргэдийн дундаж | 4.31  | 4.19  | 4.19                              | 4.22               | 4.19                                       | 4.08                     | 4.12   | 4.17   |
| Ерөнхий дундаж                | 4.41  | 4.31  | 4.25                              | 4.17               | 4.15                                       | 4.02                     | 4.06   | 4.08   |

Судалгаанд хамрагдсан сонсголын бэрхшээлтэй иргэдээс бусад хүмүүстэй хэрхэн харьцаг вэ гэсэн асуултанд хариулсан байдалд шинжилгээ хийж үр дүнг Хүснэгт 7-д харуулав. Эндээс үзэхэд сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн 84.7 хувь нь сонсголтой хүнтэй бичгээр харилцаж чадна гэсэн бол 11.9 хувь нь харьцаж отг чадахгүй гэж хариулжээ. Харин сонсголын бэрхшээлтэй хүнтэй хурууны үсгээр, дохиогоор бүгдээрээ шахуу харьцаж чаддаг ба 6.8 хувь нь л харьцаж чаддаггүй гэсэн байна.

#### Xүснэгт 7. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн бусад хүмүүстэй харьцах хэлбэрүүд

|                                | Бичгээр | Хурууны<br>үсгээр | Дохиогоор | Огт харьцаж<br>чаддаггүй |
|--------------------------------|---------|-------------------|-----------|--------------------------|
| Сонсголтой иргэдтэй            | 84.7    | 76.3              | 79.7      | 11.9                     |
| Сонсголын бэрхшээлтэй иргэдтэй | 86.7    | 91.5              | 96.6      | 6.8                      |

Судалгаанд хамрагдсан сонсголтой иргэдээс сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн харьцаг вэ гэсэн асуултанд хариулсан байдлаас үзэхэд хүмүүсийн 72.2 хувь нь бичгээр харьцаг гэжээ. Мөн бүгд хурууны үсэг ашиглан харьцаг гэсэн байна. Түүнчлэн 97.2 хувь нь дохиогоор харьцаг бол 2.8 хувь нь харьцаж чаддаггүй гэж хариулжээ (Хүснэгт 8).

---

**Хүснэгт 8. Сонсголтой иргэдийн бусад хүмүүстэй харьцах хэлбэрүүд (хувиар)**

|                                | Бичгээр | Хурууны<br>үсгээр | Дохиогоор | Огт харьцаж<br>чаддаггүй |
|--------------------------------|---------|-------------------|-----------|--------------------------|
| Сонсголын бэрхшээлтэй иргэдтэй | 72.2    | 100.0             | 97.2      | 2.8                      |

Судалгааны үр дүнгээс харахад сонсголтой иргэд сонсголын бэрхшээлтэй иргэдтэй бичгээр харьцахаас гадна хуруу, дохионы хэлийг нилээд ашигладаг бол сонсголын бэрхшээлтэй иргэд сонсголтой иргэдтэй бичгээр илүү харьцаг байна.

Бусад хүмүүстэй харьцаж чаддаггүй гол шалтгаан нь юу вэ гэсэн асуултанд хариулт өгсөн сонсголтой иргэдийн 14.7 хувь нь нэгдсэн дохионы хэл байхгүй, 12.6 хувь нь хүмүүс дохио мэддэггүй гэсэн хариулт өгсөн нь тэдний хувьд нийгмийн гол шалтгаанууд болж байв. Харин харилцаанд орж чадахгүй байх гэж эмээдэг, бусдаас хол байх эрмэлзэлтэй гэсэн хувийн шалтгаануудаас болж бусадтай харьцаж чаддаггүй гэсэн хариултуудыг сонсголтой иргэд дурдсан байна.

Харин сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд 28.4 хувь нь нэгдсэн дохионы хэл байхгүй гэдгийг нийгмийн гол шалтгаан болгожээ. Хувийн шалтгаанаар авч үзвэл бусдаас хол байх эрмэлзэлтэй байдгаас хамаарч бусадтай харьцаж чаддаггүй гэж тэд дүгнэсэн байна (Хүснэгт 9).

---

**Хүснэгт 9. Хүмүүстэй харьцахад саад болж буй шалтгаанууд (Хувиар)**

| Нийгмийн<br>талаас   | Нэгдсэн дохионы хэл байхгүй                                       | Сонсголын бэрхшээлтэй<br>эсэх |      |
|----------------------|---|-------------------------------|------|
|                      |   | Үгүй                          | Тийм |
| Хувь хүний<br>талаас | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд<br>тусалдаг хүн цөөн                 | 3.2                           | 10.5 |
|                      | Сонсголын бэрхшээлтэй иргэдийн<br>талаарх мэдлэг дутмаг           | 5.3                           | 7.4  |
|                      | Ихэнх хүмүүс сонсголын бэрхшээлтэй<br>иргэдийг хүүхэд лугаа үздэг | 2.1                           | 3.2  |
|                      | Хүмүүс дохионы хэл мэддэггүй                                      | 12.6                          | 12.6 |
|                      | Харилцаанд орж чадахгүй гэж эмээдэг                               | 10.3                          | 17.9 |
|                      | Байнга эргэлзэж байдаг  | 2.6                           | 6,4  |
|                      | Бусдаас хол байх эрмэлзэлтэй                                      | 10.3                          | 34.6 |
|                      | Буруу ойлгодог  |                               | 3.8  |
|                      | Өөртөө итгэлгүй   | 3.8                           | 5.1  |
|                      | Бие болон сэтгэл зүйн дутуу хөгжилтэй                             | 3.8                           | 1.3  |

Судалгааны үр дүнгээс сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд хоёуланд нь адилхан нэгдсэн дохионы хэл байхгүй гэсэн нийгмийн, бусдаас хол байх эрмэлзэлтэй гэсэн хувийн шалтгаанууд бусадтай харьцахад нь саад бодлог юм байна гэж дүгнэхээр байна.

## 1.5 Хэрэгцээ

Судалгаанд хамрагдагсдын 67.8 хувь нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд төр тусална гэж үзэж байгаагийн 45.2 хувийг сонсголын бэрхшээлтэй иргэд хариулсан байв (Хүснэгт 10). Энэ нь сонсголтой иргэдтэй харьцуулбал сонсголын бэрхшээлтэй иргэд илүү төрдөө найдаж, бидэнд тусалж чадна гэж боддог байна. Түүнчлэн гэр бүл, ойр дотныхон тусална гэсэн хандлагатай хүмүүс судалгаанд хамрагдагсдын дунд нилээд дээгүүр байрыг эзэлж байна.

**Хүснэгт 10. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд туслах боломжтой байгууллага, хүмүүсийг тодорхойлсон байдал**

| Байгууллага, хүмүүс      | Сонсголын бэрхшээлтэй эсэх |      |
|--------------------------|----------------------------|------|
|                          | Үгүй                       | Тийм |
| Төр засаг                | 22.6                       | 45.2 |
| Төрийн бус байгууллагууд |                            | 3.2  |
| Гэр бүл хамт олон        | 15.1                       | 9.7  |
| Би өөрөө                 | 1.1                        | 3.2  |
| Нийт                     | 38.7                       | 61.3 |

Сонсголын бэрхшээлтэй иргэдэд юу хамгийн чухал вэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 71.6 хувь (үүний 58.8 хувь нь сонсголын бэрхшээлтэй иргэд) нь *сурч хөгжих боломж нөхцөл*, 69.5 хувь (үүний 72.7 хувь нь сонсголын бэрхшээлтэй иргэд) нь *тайван түгшиүүргүй амьдрал*, 47.5 хувь (үүний 66.7 хувь нь сонсголын бэрхшээлтэй иргэд) нь *хөдөлмөр эрхлэлт* гэж хариулжээ. Эндээс үзэхэд сонсголын бэрхшээлтэй иргэдэд сурах, хөдөлмөрлөх, тайван амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд туслах нь нэн тэргүүний хэрэгцээ болж байна.

Сэтгэл зүйн дэмжлэг болон дохионы хэл нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд чухал хэрэгцээтэй хэмээсэн нь удаах байруудад харагдаж байна. Харин энд сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлийг илүү чухал гэж үзсэн бол сонсголтой иргэд сэтгэл зүйн дэмжлэгийг илүү хэрэгцээтэй гэжээ. Энэ нь дохионы хэлний мэдлэг олгох сургалтуудыг явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бодлого, үйл ажиллагааг төр засгаас авч хэрэгжүүлэх нь нийгмийн халамж шаардагдсан иргэдийн нийгэмд идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц болох нь тодорхой байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс нэмэлт саналын талаар асуусан асуултын хариултаас үзэхэд хариулагчдын дийлэнх нь дохионы хэлний сургалтыг давтан явуулахыг хүссэн байна.

## Дүгнэлт

1. Дохионы хэлний анхан шатны сургалтаар сонсголтой ба сонсголын бэрхшээлтэй иргэдийн дохионы хэлний мэдлэг, чадвар дээшилсэн хувь өндөр байгаа нь сургалт чухал ач холбогдолтой, үр дүнтэй болсныг илтгэж байна.
2. Сонсголтой иргэд сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харьцах, мөн сонсголын бэрхшээлтэй иргэдийн харилцааны гол хэрэгсэл нь дохионы хэл байна.

3. Сонголын бэрхшээлтэй иргэдийн нилээд хэсэг нь жирийн иргэдтэй огт харьцаж чаддаггүй байна. Үүний гол шалтгаан нь сонголтой иргэдийн хувьд дохио мэддэггүй, сонголын бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгмийн талаас нэгдсэн дохионы хэл байхгүй явдал, харин хувь хүний талаас харилцаанд орж чадахгүй байх гэж эмээдэг, мөн бусдаас хол байх эрмэлзэлтэй байдагтай холбоотой байна.
4. Сонголтой ба сонголын бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь төр сонголын бэрхшээлтэй иргэдэд тусалж чадна хэмээн үздэг байна.
5. Сонголтой ба сонголын бэрхшээлтэй иргэдийн үзэж буйгаар тэдэнд нэн тэргүүн:
  - *сурч хөгжих боломж нөхцөл*
  - *тайван түгшиүүргүй амьдрал*
  - *хөдөлмөр эрхлэлтийг хамгийн хэрэгтэй зүйл гэж үзэж байна.*

### **Санал, зөвлөмж**

- Дохионы хэлний анхан шатны сургалтыг насын онцлог, байршил, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтмол явуулж байх. Сургалтаар олж авсан мэдлэгээ амьдралд хэрэглэх боломж, нөхцөл буй эсэхэд анхаарч давтан сургалтанд хамруулах;
- Телевиз болон олон нийтийн мэдээлэх хэрэгслээр мэдээллийг дохионы хэлээр явуулах, олон нийтэд ойлголт, мэдлэг олгох сургалтуудыг явуулах;
- Сонголын бэрхшээлтэй иргэд сурч хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэх, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах;
- Сонголын бэрхшээлтэй иргэдийн оршин суугаа дүүрэг, ажил амьдралын орчинг тайван, аюулгүй байлгах нөхцөл боломжоор хангах;
- Сонголын бэрхшээлтэй иргэдэд хандсан нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Сонголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд энэ чиглэлээр хийгдэж байгаа санаачлагуудыг дэмжих, хамтран ажиллахыг төр, олон нийт болон боловсролын байгууллагуудад уриалах.